



VACUUM CLEANER



**MODEL: RVCM163GR
INSTRUCTION MANUAL**

Thank you for purchasing a household cleaning appliance from the Rotenzo brand.

To facilitate your use, please read this instruction manual carefully to understand how to operate this product safely and correctly, and to obtain the desired results from it.


TECHNICAL PARAMETERS

MODEL	RVCM163GR
RATED POWER	2000 W
SUCTION POWER	420 W
NOISE LEVEL	≤78 Db
DUST CAPACITY	2 L

SAFE USE GUIDELINE

1. For the first operation, it is advisable to read the manual carefully before hand and keep it properly for future use.
2. Before the first operation, make sure the dust cup is properly installed.
3. Make sure the power supply is 220-240V/ 50Hz
4. Do not vacuum water and inflammable material
5. Do not vacuum burning material and ashes
6. Do not use the machine without a motor protection filter filled
7. Disconnect power before changing attachments, removing dust container and maintaining appliance.
8. Please change the dust cup/HEPA immediately when it is damaged.
9. Do not store or use the machine close to high temperature places
10. Do not let children use the machine in case of any danger
11. If abnormal noise, smell, smoke or any other failure or breakage was found during the operation, you should turn off the switch and unplug it. Then contact with your service center for repair. Do not repair it by yourself.
12. If the supply cord is damaged, it must be replaced by the manufactures or its service agent or a similarly qualified person in order to avoid a hazard.

INTRODUCTION TO PRODUCT COMPONENTS



1	Handle	7	Dust cup
2	Release button	8	Hose connector
3	Cord rewind button	9	Hose
4	Power button	10	Brush tool
5	Rubber for big wheel	11	Extending metal tube
6	Big wheel	12	Two in one brush

ASSEMBLY BEFORE USE

Fig.1 shows the connection of the hose and the vacuum cleaner:

Put the hose connector in front of the vacuum cleaner .Then insert it into the inlet hole . If you want to disassemble it, you can press the release button and then pull it out.

Fig.2 shows the connection of the hose and the extending metal tube:

Hold the flexural connector of the hose and put it into the bigger hole of the tube.

Fig.3 shows the connection of the tube and the brush tool:

Put the metal tube into the hole of the brush and rotate it to fasten them.

Fig.4 shows how to check the winding of the power cord.

You can pull the power cord out of the machine and stop it when you see the yellow mark. Make sure the red mark is not out. When your sweep is over, first turn off the power, pull the plug out of the socket, and then push the winding device button until the cord is completely in the machine.

Fig.5 shows the power button

Put the plug into the socket, push the power button to control the work of the machine.




Fig.1




Fig.2




Fig.4




Fig.3

CLEANING OF THE DUST CUP

The steps of the dust cup cleaning:

1. As in Fig.6, hold the dust cup and handle and push the release button.
2. As in Fig.7, take the dust cup out of the machine.
3. As in Fig.8, put the dust cup onto the rubbish bin, push the release button to open the bottom of the dust cup, and the dirt and dust will fall into the bin by itself.
4. As in Fig.9, shut up the dust cup for a circular use after your cleaning




Fig.5




Fig.6




Fig.8




Fig.7




Fig.9

HOW TO USE THE ATTACHMENTS

1. As in fig.10, you can use the two in one brush in the corner and the aperture.
2. As in fig.11, open the other side with bristles of the two in one brush as the mark of an arrow to clean the sofa, the curtain and the dust on the ornaments.
3. As in fig.12, tread on the pedal of the brush tool to let the bristles out, and you can clean the floor.
4. As in fig.13 , tread on the pedal of the brush tool again to put the bristles in, and you can clean the carpet.





Fig.11




Fig.12




Fig.13

HOW TO MAINTAIN

1. The filter should be cleaned twice a year, and when there is obvious dirt on the filter, it is time.
2. You must fix the filter properly before running the vacuum cleaner.
3. The filter can't be cleaned in the washing machine or baked by the blower.
4. It will reduce the suction power and damage the motor if you use the wet filter.

5. Steps for maintenance of HEPA FILTER

- 1) As in fig.14, press the outlet lock to open the outlet board.
- 2) As in fig.15, get out the outlet filter.
- 3) As in fig.16, rotate the HEPA cover to separate it from the dust cup cover
- 4) As in fig.17, get the HEPA cover
- 5) As in fig.18, take the filter out and tap it to remove the dust. If necessary, you can rinse it under water tap.
- 6) Wash the HEPA cover, the HEPA assembly, the outlet sponge and the dust chamber in the water without detergent and dry them before use. Don't use any tools to brush the HEPA filter paper, otherwise the HEPA filter will be damaged and filtration effect will be affected.
- 7) Fix the HEPA assembly on the chamber cover and make sure three salient cubes should be stuck in the grooves of the dust chamber.
- 8) Rotate the HEPA assembly in the direction of the mark on the chamber cover.
- 9) Assemble the chamber cover assembly and the dust chamber according to the mark outside.
- 10) Put the dust chamber assembly into the machine. And in this process, first you should make the chamber in the right position and then press the handle of the dust chamber, if there is a cluck it means the operation is successful.




Fig.14




Fig.15




Fig.16




Fig.17




Fig.18

Correct Disposal of this product



This marking indicates that this product should not be disposed with other household wastes throughout the EU. To prevent possible harm to the environment or human health from uncontrolled waste disposal, recycle it responsibly to promote the sustainable reuse of material resources. To return your used device, please use the return and collection systems or contact the retailer where the product was purchased. They can take this product for environmental safe recycling.

 **Rotenzo**

ТООС СОРОГЧ



ЗАГВАР: RVCM163GR

ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА

Rotenzo брэндийн тоос сорогчийг сонгосон танд баярлалаа.

Гарын авлагыг хэрэглэгч та бүхэнд бүтээгдэхүүнийг зөв, бүрэн гүйцэд ашиглахад туслах үүднээс бэлтгэв.

Тоос сорогчийг ашиглахын өмнө гарын авлагатай танилцана уу!

Хэрэглэгчийн гарын авлагатай танилцсаны дараа бүтээгдэхүүний гэмтэл засвар болон гарч болзошгүй гэмтлийг засварлах үүднээс гарын авлагыг хадгална уу!

Бусдад дамжуулахаар бол гарын авлагыг хамтад нь өгнө үү!

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ


ЗАГВАР	RVCM163GR
ХҮЧИН ЧАДАЛ	2000 Ватт
СОРОХ ХҮЧ	420 Ватт
ДУУ ЧИМЭЭНИЙ ТҮВШИН	≤78 дБ
ТООСНЫ САВНЫ БАГТААМЖ	2 литр

САНАМЖ

- Тоос сорогчийг ашиглахын өмнө хэрэглэгчийн гарын авлага дахь заавартай танилцана уу.
- Тоос сорогчийг зөвхөн ахуйн зориулалтаар хэрэглэнэ.
- Тоос сорогчийг ашиглаагүй үед унтрааж, цахилгаанаас салган, хоолойг их биеэс салгаж хадгална.
- Цахилгааны утаснаас татаж болохгүй бөгөөд цахилгааны утсыг чөлөөтэй байлгах хэрэгтэй.
- Тоос сорогчийн цахилгааны утас гэмтсэн тохиолдолд тоос сорогчийг хэрэглэж болохгүй ба баталгаат засварын төвд засуулна. Гэмтэлтэй утсыг залгуураас сайн барьж салгах ба цахилгааны утаснаас татаж салгаж болохгүй.
- 8-аас доош насны хүүхдээс хол байлгана уу, 8-аас дээш настай хүүхдэд зааварчилгаа өгсөн тохиолдолд хэрэглэж болно.
- Нойтон гартай тоос сорогчийг хэрэглэж, тогноос салгаж болохгүй.
- Тоос сорогчийг ажиллаж байх үед хараа хяналтгүй орхиж явж болохгүй.
- Тоос сорогчийг хэрэглэж байх үед агаар гадагшлуулах хэсгийг бөглөж болохгүй. Учир нь тоосны шингэлт, хуримтлал нь хөдөлгүүрийг гэмтээх өндөр эрсдэлтэй байдаг.
- Тоос сорогчийг хэт халуун газар болон халуун эх үүсгүүрээс хол байлгах шаардлагатай ба тоос сорогчийн хуванцар хэсгүүд хайлж, гэмтэх аюултай.
- Тоос сорогчийг хэрэглэхийн өмнө шалан дээрх хурц өнцөгтэй болон том хог хаягдлыг цэвэрлэж, шүүлтүүр болон хөдөлгүүр, хуванцар хэсгүүдийг гэмтэхээс сэргийлнэ үү.
- Тоос сорогчоор шингэн төрлийн бодис соруулж болохгүй бөгөөд энэ нь тоос сорогчийн хөдөлгүүрийг гэмтээх аюултай.
- Тоос сорогчоор бөөгнөрсөн үс болон резинэн биет зэрэг хог соруулахаас сэргийлэх хэрэгтэй. Ийм төрлийн хог нь тоос сорогчийн хоолой болон соролтын нүхийг бөглөж, хөдөлгүүрийг гэмтээх, эвдлэх аюултай. Хэрэв ийм төрлийн биет тоос сорогчийн хоолойд орвол нэн даруй цахилгаанаас салган, хоолой дахь бөглөрсөн хогийг гаргаж авна уу.

БҮТЭЦ, ЭД АНГИ

Тоос сорогчийг угсарч ашиглахын өмнө эд ангиуд бүрэн байгаа эсэхийг шалгана уу!



- | | |
|---------------------------------|--------------------------------|
| 1. Тоосны савны бариул | 7. Тоосны сав |
| 2. Тоосны савыг салгах товчлуур | 8. Уян хоолойн төгсгөл |
| 3. Залгуур хураах товчлуур | 9. Уян хоолой |
| 4. Асаах/ унтраах товчлуур | 10. Шал цэвэрлэх сойз |
| 5. Резин дугуй | 11. Сунадаг төмөр хоолой |
| 6. Дугуй | 12. Хоёр үйлдэлтэй жижиг хошуу |

УГСРАЛТ

Угсрахаас өмнө цахилгааны эх үүсгүүрээс салгасан эсэхээ шалгана уу!

Зураг 1. Уян хоолойг их биед угсрах ба салгах

Уян хоолойг их биеийн урд хэсэгт байрлах оролтод хийж угсарна. Салгахдаа хоолойн төгсгөлд байрлах түгжээн дээр дараад сугалж татна.

Зураг 2. Уян хоолой болон сунадаг төмөр хоолойг угсрах


Уян хоолойн тахир хэсгийг төмөр хоолойд залгаж угсарна.

Зураг 3. Төмөр хоолой болон шал цэвэрлэх сойзыг угсрах


Төмөр хоолойг сойзны нүхтэй хэсэгт углаж, эргүүлэн чангална.

Зураг 4. Цахилгааны утсыг сунгах болон хураах


Цахилгааны утсыг татаж гаргах ба шар тэмдэглэгээ гарч ирэх үед зогсоно. Энэхүү тэмдэглэгээ нь цахилгааны утас боломжит хэмжээгээр гарсан байгааг илэрхийлэх ба улаан өнгийн тэмдэглэгээг гартал цахилгааны утсыг сунгаж болохгүй. Цэвэрлэгээг хийж дууссаны дараа утсыг цахилгаанаас салгаж, цахилгааны залгуур хураах товчлуур дээр дарж, бүрэн гүйцэд хураана.




Зураг 1



Зураг 2



Зураг 3




Зураг 4

ТООС СОРОГЧИЙГ ЦЭВЭРЛЭХ, ХАДГАЛАХ


Тоос сорогчийг цэвэрлэх дараалал

5. Зураг 5-д үзүүлснээр тоосны савны бариулаас барьж, салгах товчлуур дээр дарж их биеэс салгана.

6. Зураг 6-д үзүүлснээр хогийн саван дээр байрлуулж, тоосны савны доор байрлах нээх товчлуурыг дарж хогийг асгана. Хог унаж цэвэрхэн болсны дараа тагийг хаана.



Зураг 5




Зураг 6

АНХААРУУЛГА

- Тоос сорогчийг ашиглахаас өмнө шүүлтүүрийг байршуулсан байх шаардлагатай.
- Шүүлтүүрийг угаалгын машинд угааж болохгүй.
- Шүүлтүүрийг сайтар хатаасны дараа хэрэглэх ба чийгтэй эсвэл нойтон шүүлтүүр нь моторыг гэмтээнэ.

Агаарын урсгал гарах хэсгийн шүүлтүүрийг цэвэрлэх

Зураг 7-д үзүүлснээр тоос сорогчийн их биеийн ард байрлах тагийг нээж, шүүлтүүрийг авч цэвэрлэнэ.



Зураг 7


Тоосны саванд байрлах шүүлтүүрийг цэвэрлэх

Зураг 8-д үзүүлснээр тоосны савны дээд тагийг эргүүлж нээнэ. Тагнаас ХЕПА шүүлтүүрийг авч цэвэрлэнэ.



Зураг 9-т үзүүлснээр шүүлтүүрийг салгасны дараа савны тоос шороог усаар угааж цэвэрлэж болно.

АНХААРУУЛГА

ХЕПА шүүлтүүрийг ямар нэгэн сойз болон бусад хатуу зүйлсээр угааж болохгүй. Урж гэмтээх эрсдэлтэй.



Зураг 8



Зураг 9


Хадгалалт

Тоос сорогчийг нар тусах газар болон чийгтэй газар хадгалж болохгүй. Тоос сорогчийг гэрийн нөхцөлд хуурай газар хадгална. Хадгалахдаа шалны хошууг салгаж хураах эсвэл өлгөж тогтооно.




Дагалдах хэрэгслийг ашиглах

5. Хоёр үйлдэлтэй жижиг хошуу нь жижиг талбай, буланг цэвэрлэхэд тохиромжтой. Зураг 10-д үзүүлснээр сумны дагуу эргүүлж, сойзон хошууг гаргах ба энэхүү хошуугаар буйдан, хөшигийг цэвэрлэхэд тохиромжтой.

6. Зураг 11-д үзүүлснээр үндсэн хошууны хажууд байрлах товчлуур дээр дарж, сойзыг гаргана.



Зураг 10



Зураг 11

ГЭМТЭЛ, ЗАСВАР

АНХААРУУЛГА

Хөдөлгүүрт ачаалал өгч халаах, улмаар эвдрэл гэмтлээс сэргийлж, соролтын гарцыг саадгүй байлгах хэрэгтэй.

Бүтээгдэхүүнд гарсан аливаа гэмтлийг доорх зааварчилгааны дагуу засварлана. Хэрэв гэмтлийг засах боломжгүй тохиолдолд засварын төвтэй холбогдоно уу!

Гэмтэл	Засвар
Тоос сорогч ажиллахгүй байх.	1. Залгуур бүрэн залгагдсан буюу хөндийрсөн эсэхийг шалгана. 2. Цахилгааны эх үүсвэр байгаа эсэхийг шалгана. 3. Тоос сорогчийн асаах товчлуур дээр дарсан эсэхийг шалгана.
Соролтын хүч багасах.	1. Шалны хошуу болон хоолой бөглөрсөн эсэхийг шалгаж, бөглөсөн зүйлийг гаргана. 2. Агаар сорох шүүлтүүр тоосоор дүүрсэн эсэхийг шалгаж, цэвэрлэх эсвэл агаар сорох – гаргах HEPA шүүлтүүрийг солино.
Ажиллах үед хөдөлгүүрээс хэвийн бус дуу гарах.	1. Тоос сорогчийг унтраана. 2. Шалны хошуу болон хоолой бөглөрсөн эсэхийг шалгаж, бөглөсөн зүйлийг гаргана.

Хэрэглээнээс гарсан хуучин цахилгаан бараа хаягдал, устгал

Цахилгаан болон электрон тоног төхөөрөмжийн хог хаягдал (Waste Electrical and Electronic Equipment 'WEEE') 2002/96/EC -ын Европ дахь удирдлагууд дараах байдлыг тодорхойлсон байна.



Хуучин цахилгаан барааны хог хаягдлыг энгийн хог хаягдалтай хольж хаяж болохгүй бөгөөд энэ нь байгаль орчны болон хүрээлэн буй орчин, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн нэг учир эдгээр хохирлыг багасгахын тулд хуучин цахилгаан барааны хог хаягдлыг хотын хог хаягдлаас ялгаж тусад

нь устгалд оруулж байх мөн хуучин цахилгаан барааны эд ангиуд дахин ашиглагдах материалд ордог тул тусад нь ялгаж ашиглаж болох хэсгүүдийг дахин ашиглах боломжтой гэж үзнэ. Энэхүү тэмдэглэгээ нь таны худалдан авсан ахуйн хэрэгцээний цахилгаан болон электрон бараа дээр байвал уг барааг хаях үедээ тусад нь ялгаж байх гэсэн тэмдэг юм.

Худалдан авагч хуучин цахилгаан бараа болон электрон бараа тэдгээрийн хог хаягдлыг хэрхэн хаана устгалд оруулж болох дахин ашиглах, эс ашиглах зэргийг орон нутгийн захиргаа болон Нэкст Электроникс ХХК – ийн засвар үйлчилгээний төвөөс авч болно. Монгол улсын хэмжээнд хуучин хэрэглээнээс гарсан цахилгаан барааг устгах тухай, хаана хэрхэн хаях талаар тодорхой мэдээлэл хараахан гараагүй ч манай Нэкст Электроникс ХХК нь удахгүй энэ асуудлыг шийдвэрлэх гарцыг олж хэрэглэгч үйлчлүүлэгч танд мэдээлэл хүргэх болно. Бидний амьдралын өлгий болсон байгаль орчноо хамгаалахад хүн бүхний оролцоо хамгаас чухал билээ.

Нэкст Электроникс ХХК – ийн Засвар үйлчилгээний төвийн хаяг: Нэкст Сервис Засварын төв, Ард Аюуш өргөн чөлөө, Баянгол дүүрэг-13, Улаанбаатар хот, Монгол улс.

